

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ
(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрхзүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж

2.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1“биеийн тамир” гэж хүний бие бялдраа хөгжүүлэх, эрүүл мэндээ бэхжүүлэх, хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор хийгдэжбайгаа үйл ажиллагааг;

3.1.2.“спорт” гэж биеийн тамирын хөгжлийн үр дүнд бий болж, тэмцээнд тусгай журмын дагуу бэлтгэж, шударгаар өрсөлдөж байгаа үйл ажиллагааг;

3.1.3.“мэргэжлийн спорт” гэж тухайн спортын төрлөөр өндөр зэрэглэлийн тамирчдын өрсөлдөөнийг ашиг олох зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг;

3.1.4.“үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэстний онцлог шинжийг агуулсан үйл ажиллагааг;

3.1.5.“идэвхтэй хөдөлгөөн” гэж хүний булчингийн үйл ажиллагааны тусламжтайгаар зорилготой, тогтмол, тодорхой хугацаанд хүч зарцуулан хийж байгаа хөдөлгөөнийг;

3.1.6.“чийрэгжүүлэлт” гэж хувь хүний бие бялдрын онцлог, тусгай хэрэгцээнд тохирсон идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэндийг бэхжүүлэх, сэргээн засах үйл ажиллагааг;

3.1.7.“биеийн тамирын боловсрол” гэж биеийн тамир, спортоор хичээллэхэд хувь хүний эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг;

3.1.8.“биеийн тамирын ажил, үйлчилгээ” гэж иргэдийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, биеийн тамирын боловсрол олгох, чийрэгжүүлэх, биеийн тамираар хичээллэхнөхцөлийг бүрдүүлэх бүхий л үйл ажиллагааг;

3.1.9.“спортын ажил, үйлчилгээ” гэж тамирчдыг сургалт-дасгалжуулалтаар бэлтгэх, спортын тэмцээн, наадам зохион байгуулах, оролцогч талуудын цогц үйл ажиллагааг;

3.1.10.“спортын тэмцээн” гэж спортын тодорхой төрлөөр тогтоогдсон дүрмийн дагуу тамирчдын шударга өрсөлдөөнийг хангах арга хэмжээг;

3.1.11.“спортын наадам” гэж спортын төрлүүдийн тэмцээнийг нэгдсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа спорт, соёл урлагийн цогц арга хэмжээг;

3.1.12.“тамирчин” гэж спортын тодорхой төрлөөр тогтмол хичээллэж,спортын тэмцээн, наадамд оролцдог этгээдийг;

3.1.13.“өндөр зэрэглэлийн тамирчин” гэж спортын тодорхой төрлөөр дээд амжилт үзүүлэх зорилгоор системтэй хичээллэж, тив, дэлхийн тэмцээнд тогтмол оролцдог этгээдийг;

3.1.14.“мэргэжлийн тамирчин” гэж спортын тодорхой төрлөөр мэргэшиж, түүгээрээ дагнан хичээллэн, ашгийн төлөө мөнгөн урамшуулал авдаг этгээдийг;

3.1.15.“биеийн тамир, спортын ажилтан” гэж биеийн тамир, спортын мэргэжил эзэмшсэн болон биеийн тамир, спорт, спортын анагаах ухааны чиглэлээр мэргэшин ажиллаж байгаа этгээдийг;

3.1.16.“дасгалжуулагч” гэж биеийн тамир, спортын чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, тамирчин бэлтгэх, тэднийг тэмцээнд оролцох үйл ажиллагааг удирдаж байгаа мэргэшлийн зөвшөөрөл, зэрэг бүхий ажилтныг;

3.1.17.“биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга зүйч” гэж иргэдэд биеийн тамирын боловсрол олгох, биеийн тамир, спортоор зөв хичээллэх арга барилыг зааж сургах ажил, үйлчилгээ эрхлэх мэргэжил эзэмшсэн мэргэшлийн зөвшөөрөл, зэрэг бүхий ажилтныг;

3.1.18.“спортын холбоо” гэж биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр дагнаж, тухайн спортыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үзэл санааг дэлгэрүүлэх, тамирчдыг бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагыг;

3.1.19.“биеийн тамир, спортын клуб” гэж иргэнд биеийн тамирын боловсрол олгох, чийрэгжүүлэх, сургалт-дасгалжуулалт явуулах, тамирчдыг бэлтгэх, тухайн төрлийн спортын холбоонд гишүүнчлэлтэй, биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.20.“биеийн тамир, спортын байгууллага” гэж зохион байгуулалт, бүтцийн хэлбэрээс хамаарахгүй хүн амд биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.21.“биеийн тамир, спортын байгууламж” гэж иргэд идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх, тэмцээн зохион байгуулах зориулалттай тоног төхөөрөмж бүхий ордон, заал, танхим, талбай, замыг.

4 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.иргэний биеийн тамирын боловсролоо дээшлүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх үйл явц хүртээмжтэй, сайн дурын үндсэн дээр байх;

4.1.2.иргэдэд биеийн тамирын боловсрол олгох үйл явц шинжлэх ухааны үндэслэлтэй, тасралтгүй, залгамж шинжтэй байх;

4.1.3.биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ нь төрийн бүх шатны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний харилцан үр ашигтай нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих;

4.1.4.биеийн тамир, спортын аливаа үйл ажиллагаанд шударга өрсөлдөөн, хүйсийн эрх тэгш байдлыг хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

5 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Улсын Их Хурал нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.биеийн тамир, спортын асуудлаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

5.1.2.биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

5.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

6.1.2.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах;

6.1.3.иргэдийн нас, хүйс, хэрэгцээ сонирхолд нийцсэн биеийн тамир, спортын төрлийг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөр батлах;

6.1.4. Монгол Улсыг төлөөлөн Олимп, паралимпийн наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангах Үндэсний хороог Ерөнхий сайдын шууд удирдлагын дор байгуулах;

6.1.5.Монгол Улсад олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээн, наадам болон үндэсний хэмжээний спортын наадам зохион байгуулах шийдвэр гаргах, зохион байгуулах эрх олгох журам батлах;

6.1.6.Олон улсын олимпийн хорооны ивээл дор зохион байгуулагддаг тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээн, наадам болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журам батлах;

6.1.7. допингийн эсрэг үндэсний дүрэм батлах;

6.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх;

7 дугаар зүйл.Аймаг, нийслэл,сум, дүүргийниргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

7.1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар орон нутгийн бодлого тодорхойлох;

7.1.2.биеийн тамир, спортын хөгжилд шаардагдах төсөв батлах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.3.нутаг дэвсгэрийн хэмжээнд сум, аймаг, дүүрэг, хотын аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах, үндэсний тэмцээн, наадамд баг тамирчидаа бэлтгэх, оролцуулах шийдвэр гаргах;

7.1.4.үндэсний хэмжээний болон олон улсын спортын тэмцээн, наадмыг орон нутагтаа зохион байгуулах саналаа холбогдох байгууллагад тавих;

7.1.5.биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог дэмжих;

7.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7.2.Бүх шатны Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1.харьяалах нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

7.2.2.харьяалах нутаг дэвсгэртээ иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх;

7.2.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;

7.2.4.аймаг, нийслэл, дүүрэгт биеийн тамир, спортын газар, суманд биеийн тамир-чийрэгжүүлэлтийн арга зүйч ажиллуулах;

7.2.5.өсвөр үеийн шигшээ багийгспортын 8-аас доошгүй төрлөөраймаг, дүүрэгт аймаг, нийслэлийн Засаг дарга байгуулан тухайн спортын салбар холбоотой хамтран ажиллана;

7.2.6.харьяалах нутаг дэвсгэртээ тэмцээн, наадам зохион байгуулах, баг тамирчдаабэлтгэн оролцуулах;

7.2.7.биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохируулан тоноглох;

7.2.8.биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах;

7.2.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2.аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих;

8.1.3.биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний норматив, улсын төсвөөс санхүүжүүлэх ажил, үйлчилгээг санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоох;

8.1.4.иргэдэд биеийн тамирын боловсрол олгоход төр, төрийн бусбайгууллага, аж ахуйн нэгж,иргэний оролцоог хангах;

8.1.5.биеийн тамир, спортын ажилтны төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх, дасгалжуулагч, арга зүйчдэд мэргэшлийн зэрэг олгох, хугацааг сунгах, цуцлах журам батлан мөрдүүлэх;

8.1.6.биеийн тамир, спортын байгууллагыг магадлан итгэмжлэхжурам батлах;

8.1.7.хөгжлийн бэрхшээлтэй тамирчны тэмцээнд орох ангиллыг Олон улсын паралимпийн холбооны шаардлагад нийцүүлэн тогтоох,хэрэгжүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

8.1.8.биеийн тамир, спортын чиглэлээр төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг спортын холбоодоор гэрээгээр хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлж болно;

8.1.9.энэ хуулийн 6.1.5, 10.1.3-д заасан тэмцээн, наадмыг зохион байгуулах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

8.1.10.үндэсний шигшээ баг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх, тамирчин, дасгалжуулагчийг сонгон шалгаруулах журмыг батлах;

8.1.11.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагуудын үүрэг

9.1. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас бусад төрийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ.

9.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.2.1.бүх шатны боловсролын байгууллагынбиеийн тамирын хичээлийн сургалтын агуулга, хугацааг боловсролын стандартаар тогтоох, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тусгах;

9.2.2.биеийн тамирын багш спортын тодорхой төрлөөр сургалт-дасгалжуулалт явуулах, түүнд нэмэгдэл хөлс, урамшуулал олгох;

9.2.3.бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь суралцагчдад биеийн тамир, спортын заал, талбай, хэрэглэл, тоног төхөөрөмжийг төлбөртэй ашиглуулахыг хориглох;

9.2.4.өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага, суралцагчдын сургуулийн орчинд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангаж, үндэсний стандартад нийцсэн биеийн тамир, спортын заал, талбай, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх асуудлыг шийдвэрлэх.

9.3.Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

9.3.1.хүн амын хөдөлгөөний хомсдлыг бууруулах асуудлыг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг хэсэг болгон зохион байгуулах;

9.3.2.спортын анагаах ухаан, сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах.

9.4.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

9.4.1.спортын гэмтлийн улмаас эрүүл мэндэд үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулах сэргээн засах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалаар санхүүжүүлэх тусламж, үйлчилгээнд хамруулах;

9.4.2.эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.4-т заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний товлोलт хугацаанд бүрэн хамрагдсанаас хойш 3 жил дараалан эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагч магадлан итгэмжлэгдсэн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн клубын биеийн тамирын урамшуулалт үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хамрагдах журмыг биеийн тамир, спортын болон төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

9.5.Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага дараах үүрэг хүлээнэ:

9.5.1.бие бүрэлдэхүүнд биеийн тамирын боловсрол олгох, биеийн тамир, спортын тэмцээн, наадам зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

9.5.2.бие бүрэлдэхүүний бие бялдрын хөгжлийн тусгай норм, норматив тогтоох, тусгай сургалтын хөтөлбөр батлан мөрдүүлэх;

9.5.3.зэвсэгт хүчний болон төрийн зарим тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын бие бүрэлдэхүүн болон ажилтныг цэргийн алба хаах, мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон спортоор хичээллэх нөхцөл бололцоогоор хангах;

9.5.4.энэ хуулийн 9.5-д заасан байгууллага дэргэдээ бие бүрэлдэхүүн, ажилтны бие бялдрын хөгжлийг хангах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тамирчин бэлтгэх чиг үүрэг бүхий биеийн тамир, спортын хороо ажиллуулах;

9.5.5.хууль тогтоомжид заасны дагуу спортын шүүгч, дасгалжуулагч болон мэргэжлийн бусад ажилтны мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээ авах.

10 дугаар зүйл. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх:

10.1 Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

10.1.2.биеийн тамир-чийрэгжүүлэлтийн нормативыг бүх насны ангиллаар боловсруулан батлах;

10.1.3.улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох;

10.1.4.биеийн тамир, спортын улсын мэдээллийн цахим сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, бүрдүүлэх;

10.1.5.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

10.1.6. тамирчин, шүүгчид улсын цол олгох спортын төрөл, болзолыг тогтоох;

10.1.7.биеийн тамирыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёс болгон хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

10.2.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах үүрэг хүлээнэ:

10.2.1.энэ хуулийн 14.2-т заасан үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, үйл ажиллагааны зохион байгуулалтыг мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих;

10.2.2.энэ хуулийн 6.1.5-д заасан журмын хэрэгжилтийг ханганүндэсний хэмжээнд зохион байгуулах спортын наадмын төрөл, хугацааг тогтоон арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;

10.2.3.биеийн тамир, спортын үйл ажиллагаатай холбогдон гарах үндэсний стандарт, дүрэм, зааврыг олон улсын спортын байгууллагын дүрэм, шаардлагад нийцүүлэн боловсруулж, шийдвэрлүүлэх;

10.2.4.иргэдийн бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшинг тогтоох, биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхтэй хөдөлгөөнийг эрүүл аж төрөх хэв маяг болгон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангах;

10.2.5.спортын эрдэм шинжилгээ, анагаах ухааны ололтыг нэвтрүүлж, судалгаа шинжилгээний хүрээг өргөжүүлэх, спортын эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн ам болон тамирчдад үзүүлэх, биеийн тамир, спортын бэртэл гэмтэл, спортын өвчин эмгэг болон хэт ачааллын улмаас тамирчин, дасгалжуулагчдын эрүүл мэндэд үүссэн үр дагаврыг арилгах сэргээн засах тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх;

10.2.6.биеийн тамир, спортын байгууллагыг магадлан итгэмжлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

10.2.7.тамирчин, дасгалжуулагч, шүүгчийн ёс зүйн дүрмийг баталж, мөрдүүлэх;

10.2.8.допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

10.2.9.иргэн бие бялдраа хөгжүүлэх, сэргээх зорилгоор хэрэглэж байгаа биологийн идэвхт бодисын хэрэглээ, импорт, худалдаа, үйлдвэрлэлд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хяналт тавих, тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бэлэглэх, худалдах, сурталчилахыг хориглох арга хэмжээ авах;

10.2.10.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ТОГТОЛЦОО

11 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний төрөл

11.1.Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ нь биеийн тамир, спорт, үндэсний спорт, мэргэжлийн спорт болон спортын шинжлэх ухааны ажил, үйлчилгээ гэсэн төрөлтэй байна.

11.2.Биеийн тамирын ажил, үйлчилгээндиргэдийн биеийн тамирын боловсролыг дээшлүүлэх, бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшинг тогтоох, идэвхтэй хөдөлгөөнийг хүн амын эрүүл аж төрөх хэв маяг болгон хөгжүүлэх зорилгоор биеийн тамир, спортын байгууллага дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулах ажил үйлчилгээ хамаарна.

11.3.Спортын ажил, үйлчилгээнд спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, хувь хүний спортын авьяасыг илрүүлэх, амжилтыг тогтоох, өндөр зэрэглэлийн тамирчдыг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, тэмцээн, наадамд зохион байгуулах, оролцуулах, бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, спортын анагаах ухааны тусламж үйлчилгээ хамаарна.

11.4. Үндэсний спортын ажил үйлчилгээнд үндэсний спортыг дэлгэрүүлэн сурталчилах, өвлүүлэн хөгжүүлэхтэмцээн, наадам зохион байгуулах ажил хамаарна.

11.5. Мэргэжлийн спортын ажил, үйлчилгээнд спортын тэмцээнийг ашиг олох хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа ажил үйлчилгээ багтана.

11.6. Спортын шинжлэх ухааны ажил үйлчилгээнд биеийн тамир, спортын шинжлэх ухааны орчин үеийн ололт, амжилт, инновацийг нэвтрүүлэх, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээ, судалгаа багтана.

12 дугаар зүйл. Биеийн тамир, спортын салбарын тогтолцоо

12.1. Биеийн тамир, спортын салбарын тогтолцоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрдэм, шинжилгээ, сургалт, судалгаа, спортын анагаах ухааны байгууллага болон спортын газар, хороо, холбоод, клуб, бусад салбар байгууллага дах биеийн тамир, спортын асуудал хариуцсан нэгжээс бүрдэнэ.

12.2. Биеийн тамир, спортын байгууллагын төрийн удирдлагын тогтолцоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, сумын биеийн тамир-чийрэгжүүлэлтийн арга зүйчээс бүрдэнэ.

12.3. Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

12.4. Дүүргийн биеийн тамир, спортын газрын даргыг Нийслэлийн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

13 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын зохион байгуулалт

13.1. Үндэсний хэмжээний тэмцээн, наадмыг дараах байдлаар зохион байгуулна:

13.1.1. Спортын төрлийн онцлогоос хамаарч сум, дүүрэг, хот, аймаг, нийслэл, бүс, улсын аваргын тэмцээн гэж зохион байгуулна.

13.1.2. Үндэсний хэмжээний наадмыг олимп, паралимп, дифлимп, тусгай олимп болон бусад наадмын мөчлөгт нийцүүлэн өсвөр үе, оюутан залуучуудын дунд зохион байгуулах үндэсний хэмжээний наадмыг 2 жилд нэг удаа, насанд хүрэгчдийн дунд зохион байгуулах үндэсний хэмжээний наадмыг дөрвөн жилд нэг удаа өвөл, зуны спортын төрлөөр энэ хуулийн 6.1.5-д заасан журмын дагуу зохион байгуулна.

13.1.3. Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулагдаагүй үндэсний спортын бусад тэмцээн, наадмыг энэ хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл. Үндэсний шигшээ баг

14.1. Үндэсний шигшээ багийн тогтолцоо нь өсвөр үеийн, залуучуудын, насанд хүрэгчдийн шигшээ багаас бүрдэнэ.

14.2. Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцох насанд хүрэгчид, залуучуудын үндэсний шигшээ багийг энэ хуулийн 8.1.10-д заасан журмын дагуу сонгон шалгаруулж, тухайн спортын холбоодын дэргэд ажиллуулна.

14.3. Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааны дүрмийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

14.4. Энэ хуулийн 14.2-т заасан спортын холбоотой биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрээ байгуулах бөгөөд үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

14.5. Оюутны дэлхийн аварга, Универсиадад Монгол Улсыг төлөөлөн оролцох шигшээ багийг залуучуудын шигшээ багаас бүрдүүлнэ.

15 дугаар зүйл. Спортын холбооны зохион байгуулалт, эрх үүрэг

15.1. Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулаагүй спортын үйл ажиллагаатай холбогдох дараах харилцааг энэ хуулиар зохицуулна.

15.2. Спортын холбоо нь олон улсын холбооны бүтэц, зохион байгуулалтад нийцсэн нэгдсэн холбоо болон салбар холбоо, клубтэй байж болно.

15.3. Спортын холбооны эдийн бус хөрөнгө нь тэдгээрийн өмч бөгөөд зөвхөн тэдний зөвшөөрөлтэйгээр ашиглана.

15.4. Спортын холбоо доор дурдсан эрх эдэлнэ:

15.4.1. спортын тухайн төрлөөр олон улс, тив, дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах;

15.4.2. бүсийн болон улсын хэмжээнд зохион байгуулах тэмцээний хуваарьт төлөвлөгөө, дүрэм, заавар, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;

15.4.3. дасгалжуулагч, шүүгчийг аттестатчилах, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих;

15.4.4. олон улсын спортын холбооны дүрэм, харти, конвенц, биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн хүрээнд салбар холбоо байгуулах, тухайн спортын төрлөөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг биеийн тамир, спортын клубт олгох, тэднийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцож ажиллах;

15.4.5.энэ хуулийн 21.5-д заасан болзолыг хангасан тамирчинд спортын зэрэг олгох;

15.4.6.олон улсын спортын холбооны дүрэм, харти, конвенцийн хэм хэмжээний заалтаар бүх шатны тэмцээнд оролцох эрхээ хязгаарлуулсан тамирчин, дасгалжуулагч, шүүгчийг спортын тэмцээн, наадамд оролцуулахгүй байхад хяналт тавих, мэдээлэх;

15.4.7.допингийн эсрэг үндэсний дүрэм, энэ хуулийн 10.2.7-д заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн тамирчин, дасгалжуулагч, шүүгчийн спортын тэмцээн, наадамд оролцох эрхийг хасах хүртэл хариуцлага ногдуулах, холбогдох байгууллагад болон олон нийтэд мэдээлэх;

15.4.8.аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулан хамтран ажиллах;

15.4.9.тухайн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс дэмжлэг авах;

15.4.10.хуульд заасан бусад эрх.

15.5.Спортын холбоо доор дурдсан үүрэг хүлээнэ:

15.5.1.олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, үйл ажиллагааны тайлан мэдээг цаг тухайд гарган биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргэх;

15.5.2.спортын тухайн төрөл, тамирчин, дасгалжуулагч, шүүгчийг хөгжүүлэх дунд, урт хугацааны бодлого, хөтөлбөртэй байх, биеийн тамир, спортын төрийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулах;

15.5.3.салбар холбоо, клубээр дамжуулан иргэдэд биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ үзүүлэх;

15.5.4. тамирчдын сургалт-дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, шигшээ баг бүрдүүлэн тэмцээн, наадамд оролцуулах;

15.5.5.тухайн спортын төрлөөр биеийн тамир, спортын ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

15.5.6.холбооны бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулсан тэмцээн, наадам, тамирчдын амжилт, спортын цол, зэрэг, гишүүнчлэлээр мэдээллийн цахим сантай байх;

15.5.7.үйл ажиллагаандаа допинг, ялгаварлал, хүчирхийлэл, бэлгийн дарамтын аливаа хэлбэрийг гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг таслан зогсоох;

15.5.8.тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлдвэрлэх, тамирчдад хэрэглүүлэх, сурталчилахтай тэмцэх;

15.5.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

16 дугаар зүйл.Биеийн тамир, спортын клубын зохион байгуулалт, эрх, үүрэг

16.1.Биеийн тамир, спортын клуб нь иргэдэд биеийн тамирын боловсрол олгох, дасгал, идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэндийг бэхжүүлэх, спортын сургалт-дасгалжуулалт явуулж тамирчинг тэмцээн, наадамд бэлтгэн оролцуулах ажил, үйлчилгээ эрхэлнэ.

16.2.Биеийн тамир, спортын клуб нь төрийн бус байгууллагын болон аж ахуйн нэгжийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд тухайн спортын төрлийн холбоонд бүртгэлтэй байна.

16.3.Биеийн тамир, спортын клуб доор дурдсан эрх эдэлнэ:

16.3.1.хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагааны дүрэм, дотоод журмаа батлан мөрдүүлэх;

16.3.2.тамирчин, дасгалжуулагч, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга зүйч, эмч, судлаачтай хамтран ажиллах гэрээ байгуулах;

16.3.3.хууль тогтоомжид заасан бусад эрх.

16.4.Биеийн тамир, спортын клуб доор дурдсан үүрэгтэй:

16.4.1.сургалт-дасгалжуулалт болон спортын заал, талбайн стандартын шаардлагыг хангаж ажиллах;

16.4.2.спортын холбоонд бүртгүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, тогтоосон хугацаанд мэдээ тайланг хүргүүлэх;

16.4.3.иргэд, тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлдвэрлэх, тамирчдад зааж сургах, хэрэглүүлэх, сурталчилахыг хориглох;

16.4.4.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

17 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж дэх биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ

17.1.Өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгж нь биеийн тамир, спортын дараах ажил, үйлчилгээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ:

17.1.1.ажлын байрны онцлог нөхцөлтэй уялдуулан ажилтан, албан хаагчдын биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх;

17.1.2.байгууллагын нийт төсвийн 1-ээс багагүй хувийг ажилтан, албан хаагчдыг биеийн тамир, спортоор хичээллэхэд ажил, үйлчилгээнд зарцуулах;

17.1.3.ажилд шинээр ороход иргэний бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшинг тогтоож, байгаа түвшингээс ахиулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

17.1.4.өөрийн харьяа биеийн тамир, спортын клуб байгуулан ажиллуулах, биеийн тамир, спортын ажилтантай байх;

17.1.5.ажилтны бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшинг тогтоох, бие бялдыг чийрэгжүүлэх, тэмцээн, наадам зохион байгуулах;

17.2.Амралт, сувиллын газар, хүүхдийн зуслан нь спортын заал, талбай, тоног төхөөрөмжөөр тоноглож, биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг биеийн тамирын багш, дасгалжуулагч, биеийн тамир-чийрэгжүүлэлтийн арга зүйчийн оролцоотой зохион байгуулна.

18 дугаар зүйл. Биеийн тамир, спортын байгууллагын магадлан итгэмжлэл

18.1.Магадлан итгэмжлэл нь биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ эрхэлж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллагын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны түвшин, үр дүн, сургалт-дасгалжуулалтын чанар, орчны стандартад хөндлөнгийн мэргэжлийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагаа мөн.

18.2.Биеийн тамир, спортын байгууллагын магадлан итгэмжлэл сайн дурын үндсэн дээр хийгдэнэ.

18.3.Биеийн тамир, спортын магадлан итгэмжлэлийн төрөл, шатлал, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, магадлан итгэмжлэл явуулах шинжээчийн ажиллах журам, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, үйл ажиллагааны зардлын жишгийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

18.4.Магадлан итгэмжлэлийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон хараат бус шинжээчийн баг хийнэ.

19 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын ажилтны нийгмийн баталгаа

19.1.Биеийн тамир, спортын ажилтны цалингийн тусгай сүлжээний жишгийг Төрийн албаны тухай хуулийн 28.9-д заасны дагуу Засгийн газар тогтооно.

19.2.Биеийн тамир, спортын ажилтан доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

19.2.1.хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлог, мэргэшлийн зэрэг, гүйцэтгэсэн хөдөлмөрийнхөө чанар, хэмжээнд тохирсон цалин хөлс, илүү цагийн нэмэгдэл хөлс, нөхөн олговор, тусламж, шагнал, урамшуулал авах;

19.2.2.орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж байгаа биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагч, спортын анагаах ухааны эмч, арга зүйч 4 жилд нэг удаа мэргэжил дээшлүүлэх сургалтад Боловсролын сургалтын сангийн зээлд хамрагдах;

19.3.Төрийн өмчийн биеийн тамир, спортын байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажиллаж, тэтгэвэр тогтоолгосон биеийн тамир, спортын ажилтанд 36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас тооцуулан ажиллаж байгаа байгууллагаасаа авах эрхтэй. Нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.

19.4.Энэ хуулийн 19.3-т заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоход шаардагдах зардлыг тухайн байгууллага төсөвтөө жил бүр тусгана.

20 дугаар зүйл. Тамирчны эрх, үүрэг

20.1.Тамирчин доор дурдсан эрх эдэлнэ:

20.1.1.спортын төрлөө сонгох, хичээллэх;

20.1.2.спортын тэмцээн, наадамд оролцох;

20.1.3.энэ хуулийн 21.1,21.5-д заасан болзол хангасан бол спортын цол, зэрэг авах;

20.1.4.харьяалагддаг спортын клубээс гэрээний дагуу өөр спортынклубт шилжих;

20.1.5.тэмцээнд бэлтгэх, оролцох хугацаанд үндсэн ажил, сургуулиас энэ хуулийн 8.1.9 дах хэсэгт заасан журмын дагуу чөлөөлөгдөх;

20.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

20.2. Тамирчин доор дурдсан үүрэг хүлээнэ:

20.2.1.спортын тэмцээн, наадмын үед болон бэлтгэл, дасгалжуулалтын явцад аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэх;

20.2.2.шударга өрсөлдөөнийг эрхэмлэх, допинг хэрэглэхгүй байх, допингийн шалгалтад заавал хамрагдаж байх;

20.2.3.тамирчны ёс зүйн дүрмийг мөрдөх;

20.2.4. эрүүл мэндийн үзлэг, хяналт, сургалтад хамрагдах;

20.2.5.биеийн тамир, спортоор хичээллэгчдийн эрүүл мэндэд хохирол учруулах хориотой мэх, арга барил хэрэглэх, зааж сургах, хориотой эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, худалдан авах, бэлэглэх, сурталчилхаас татгалзах;

20.2.5.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

20.3.Тамирчин доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

20.3.1.тамирчин олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээн, наадам болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртвэлЗасгийн газраас мөнгөн шагнал, урамшуулал болон бусад байгууллагын урамшуулал авах;

20.3.2.энэ хуулийн 14.2-т заасан үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагч цалин хөлс авах;

20.3.3.үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагч 2 жилд 1 удаа шаардлагатай спортын хувцас, хэрэгслээр хангагдах;

20.3.4.эрүүл мэндийн даатгалд даатгуулсан, спортын гэмтэлтэй тамирчинд үзүүлэх өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжийн дагуу санхүүжүүлэх.

21 дүгээр зүйл.Спортын цол зэрэг

21.1.энэ хуулийн 10.1.6-д заасан болзолыг хангасан тамирчинд олон улсын хэмжээний мастер, Монгол Улсын спортын мастер, дэд мастер, шүүгчид улсын шүүгч цолыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийнзахиргааны байгууллага олгоно.

21.2.спортын цолны болзол хангасан тамирчин, шүүгчид тухайн нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага мөнгөн урамшуулал олгож болно.

21.3.Монгол Улсын спортын цол хүртсэн тамирчинд харьяа байгууллага нь цолны нэмэгдэл хөлсийг тогтоон олгож болно.

21.4.энэ хуулийн 10.1.4, 15.5.6-д заасан мэдээллийн цахим санд бүртгэлгүй тамирчин, шүүгчид спортын цол олгохыг хориглоно.

21.5.тамирчин, шүүгчид спортын зэрэг олгох болзолыг тухайн спортын холбоо тогтооно.

22 дугаар зүйл.Биеийн тамир, спортын ажилтны төгсөлтийн дараах сургалт

22.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд биеийн тамир, спортын ажилтныг төгсөлтийн дараах

сургалтаар мэргэшүүлэх, давтан сургах асуудал эрхэлсэн орон тооны нэгж ажиллах бөгөөд нэгжийн дүрэм, ажиллах журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.2. Төрийн сангийн шугамаар биеийн тамир, спортын ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах журмыг биеийн тамир, спортын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САНХҮҮЖИЛТ

23 дугаар зүйл. Биеийн тамир, спортын санхүүжилт

23.1. Биеийн тамир, спортын санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөвт бие даасан зардлын зүйл байна.

23.2. Энэ хуулийн 6.1.3, 6.1.5-6.1.6, 10.1.3-10.1.5, 10.1.7, 10.2.1, 10.2.5, 10.2.8, 14.4, 19.2.2, 19.4, 20.3.2-20.3.3, 21.1-д заасан үйл ажиллагааг улсын төсвөөс, 7.1.3, 7.1.4, 7.2.2-7.2.7-д заасан үйл ажиллагааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

24 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын ивээн тэтгэлэг, хандив

24.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, спортын холбоо, спортын клуб биеийн тамир, спортын тэмцээн, наадмыг ивээн тэтгэж, хандив өгч болно.

24.2. Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг сурталчилахаас бусад зориулалтаар тухайн спортын хөгжилд зориулан үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийг спортын хандивт, хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн спортын төрлийг ашиглан өөрийн байгууллагын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг сурталчилгаах зорилгоор спортын хөгжлийг дэмжихэд чиглэсэн санхүүгийн дэмжлэгийг спортын ивээн тэтгэлэгт хамааруулна.

24.3. Биеийн тамир, спортын тэмцээн, наадамд хандив, ивээн тэтгэлэг үзүүлсэн байгууллагын сурталчилгаанд тамирчин, дасгалжуулагч гэрээний дагуу оролцож болно.

24.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас спортын хөгжилд зориулсан хандив, биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний зардал, спортын заал, талбай, түүний дэд бүтцийг барихад оруулсан хөрөнгө оруулалтыг албан татвар ногдох орлогоос хасч тооцно.

24.5. Улсын хилээр нэвтрүүлэх Монголд үйлдвэрлэдэггүй, өндөр технологи шаардсан спортын тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газар баталж, Гаалийн албан татвараас чөлөөлнө

25 дугаар зүйл. Биеийн тамир, спортын барилга байгууламж

25.1.Спортын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа үндэсний стандартыг, стандарт байхгүй тохиолдолд олон улсын спортын холбоодын дүрэмд заасан техникийн нөхцөл, шаардлагыг баримтална.

25.2.Спортын барилга байгууламжийн ашиглалтын зардлын тооцоо нь энэ хуулийн 25.1-д заасан зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг байна.

25.3.Биеийн тамир, спортын барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагад нийцсэн дэд бүтэц, хэрэгцээт тохируулгаар заавал тоноглогдсон байна.

25.4.Барилгын тухай хууль болон энэ хуулийн 23.1-д заасан шаардлага хангаагүй, спортын барилга байгууламжгүй орон сууцны хороолол барихыг хориглоно.

25.5.Төрийн болон орон нутгийн өмчид байгаа спортын барилга байгууламжийн зориулалт, ашиглалтын чиглэлийг өөрчлөх, хувьчлах, адил байгууламж барихгүйгээр буулгахыг хориглоно.

25.6.Бүх шатны боловсролын байгууллагын барилгыг биеийн тамир, спортын байгууламжгүй барих, ашиглалтад хүлээн авахыг хориглоно.

25.7.Хувийн хөрөнгө оруулалтаар барьж, магадлан итгэмжлэгдсэн спортын барилга, байгууламжийн үйл ажиллагаанд улсын болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж болно.

25.8.Төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар баригдсан, улсын төсвийн санхүүжилттэй болон энэ хуулийн 25.7-д заагдсан биеийн тамир, спортын байгууллагад хүүхэд, оюутан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх жишиг үнэ тогтоох, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн, наадам зохион байгуулахад хөнгөлөлт үзүүлэх журмыг санхүү, төсвийн болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

26 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

26.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ.

26.2.Аж ахуй нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн удирдлага энэхүү хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

26.3.Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлдэг төрийн бус байгууллага биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж болно.

26.4.Спортын холбоо өөрийн зохион байгуулж байгаа ажил, үйлчилгээнд дотоодын хяналт тавина.

26.5.Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэд, тамирчид бие бялдраа хөгжүүлэх, сэргээх зорилгоор хэрэглэж байгаа биологийн идэвхт бүтээгдэхүүний эрүүл мэндийн дүгнэлтийг төрөл тус бүрээр импортлогчдод олгож, худалдаа,үйлчилгээнд хяналт тавина.

27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол доор дурдсан захиргааны шийтгэлийг хууль тогтоомжийн дагуу шат шатны шүүгч болон тусгайлан эрх олгосон хяналтын улсын байцаагч ногдуулна.

27.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн эдгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

28.1.Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

28.2.Энэ хуулийн 9.2.4, 9.4.2 дах заалтыг 2020 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны дугаар
сарын- ны өдөр

Улаанбаатар хот

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2003 оны 10 дугаар сарын 31-ны өдөр баталсан “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20__ оны __ сарын __-ны өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлд: “12.1.36. Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн спортын хөгжилд зориулсан хандив, болон ажилтан, албан хаагчдад зориулан явуулсан эрүүл мэнд, биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний зардлыг албан татвар ногдох орлого;” гэсэн заалтыг;

2. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлд 12.1.37. “Тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээн явуулах олон улсын шаардлагыг хангасан спортын заал, түүний дэд бүтцийг барихад оруулсан хөрөнгө оруулалт;” гэсэн заалтыг;

3. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлд “12.1.38. Биеийн тамир, спортын хөгжилд зориулсан хандивт хамрагдах спортын хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт болон спортын заалны зориулалтын нэрсийг Засгийн газар батална.” гэж тус тус нэмсүгэй.

4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлд “18.1.15. “Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн спортын хөгжилд зориулсан хандив.” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн батлагдсан өдрөөс нь буюу оны дугаар сарын сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20__ оны __ сарын __-ны өдөр

Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Барилгын тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй:

“10.1.8.“спортын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа үндэсний стандартыг, стандарт байхгүй тохиолдолд тухайн спортын олон улсын спортын холбоодын дүрэмд заасан техникийн нөхцөл, шаардлагыг баримталсан.” гэж нэмэлт оруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийн батлагдсан өдрөөс нь буюу оны дугаар сарын сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20__ оны __ сарын __-ны өдөр

Улаанбаатар хот

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй:

1. Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд: “38.1.19. спортын тусгай зориулалтын тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг;” гэсэн заалтыг;

2. Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд: “38.2.Энэ хуулийн 38.1.19-д хамаарах барааны жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална;” гэсэн заалтыг тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн батлагдсан өдрөөс нь буюу оны дугаар сарын сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20__ оны __ сарын __-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй:**

1. Зөрчлийн тухай хуулийн 15.31 дугаар зүйлд: “5. Олон улсын спортын холбооны дүрэм, харти, конвенцийн хэм хэмжээний заалтаар бүх шатны тэмцээнд оролцох эрхээ хязгаарлуулсан тамирчин, дасгалжуулагчийг спортын тэмцээн, наадамд оролцуулсан, мэдээллийн цахим санд бүртгэлгүй тамирчин, шүүгчид спортын цол олгосон ажилтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, спортын цолыг хүчингүй болгох, этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэсэн заалтыг;

2. Зөрчлийн тухай хуулийн 15.31 дугаар зүйлд: “6. Биеийн тамир, спортын байгууллагад хүүхэд, оюутан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх жишиг үнэ тогтоох, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн, наадам зохион байгуулахад хөнгөлөлт үзүүлэх журмыг зөрчсөн ажилтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэсэн заалтыг;

3. Зөрчлийн тухай хуулийн 15.31 дугаар зүйлд: “7. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээний дагуу гүйцэтгэхдээ хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үр дүн, санхүүжилтийн тайланг олон нийтэд ил болгоогүй зөрчил гаргасан спортын холбооны удирдах ажилтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас жар дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, учирсан хохирлыг удирдах зөвлөлөөр нөхөн төлүүлж, удирдах багийг шинээр байгуулах шаардлага тавих, хэрвээ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг 2 жил хүртэлх хугацаагаар цуцлах хүртэл арга хэмжээ авах,” гэсэн заалтыг;

4. Зөрчлийн тухай хуулийн 15.31 дугаар зүйлд: “8. Спортын холбоо допингийн эсрэг үндэсний дүрэм, ёс зүйн дүрмийг зөрчсөн тамирчин, дасгалжуулагч, шүүгчд хариуцлага ногдуулаагүй, холбогдох байгууллагад болон олон нийтэд мэдээллээгүй, тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлдвэрлэх, тамирчдад хэрэглүүлэх, сурталчилах зөрчил гаргасан бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэсэн заалтыг;

5. Зөрчлийн тухай хуулийн 15.31 дугаар зүйлд: “9. Дасгалжуулагч, бусад этгээд, тамирчин шударга бусаар өрсөлдөсөн, допинг хэрэглэсэн, допингийн шалгалтаас зайлс хийсэн, тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах

эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлдвэрлэх, тамирчдад хэрэглүүлэх, сурталчилах зөрчил гаргасан бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, допингийн эсрэг үндэсний дүрмээр спортын харилцаанд оролцох эрхийг хасах;" гэсэн заалтыг;

6. Зөрчлийн тухай хуулийн 15.31 дугаар зүйлд: "10. спортын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа үндэсний стандартыг, стандарт байхгүй тохиолдолд олон улсын спортын холбоодын дүрэмд заасан техникийн нөхцөл, шаардлагыг баримталаагүй зөрчил гаргасан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар хүчингүй болгох;" гэсэн заалтыг;

2 дүгээр зүйл. Энэ хуулийн батлагдсан өдрөөс нь буюу оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА



MONGOLIAN
PARALYMPIC COMMITTEE

MONGOLIAN PARALYMPIC COMMITTEE
МОНГОЛЫН ПАРАЛИМПИЙН ХОРОО

Баяг тойруу 55, Post box 121, Central Sports Palace,
Ulaanbaatar 210648, Mongolia
Tel: +976-91913303, 99752338,
E-mail: npc976mongolia@gmail.com

2016.12.22 № 3/25

танай _____-ийн(ны) _____-т

Санал хүргүүлэх тухай

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
С.ЧИНБАТ ТАНАА

Монголын Паралимпийн хороо нь “Биеийн тамир, спортын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судалж үзлээ.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зарчмын санал байхгүй бөгөөд төслийг дэмжиж байна.

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ  Д.СҮРЭНХОРЛОО

